

**“ХААН БАНКНЫ НЭРЭМЖИТ ОЮУТНЫ ДАХИН  
ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 2024-2025”****Хөтөлбөрийн зорилго, хамрах хүрээ:**

ХААН Банк Сангаас компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх бодлогын дагуу Тогтвортой хөгжлийн “Чанартай боловсролыг дэмжих” зорилгод чиглэн “ХААН Банкны нэрэмжит оюутны дахин тэтгэлэгт хөтөлбөр 2024-2025”-ийг нээлттэй зарлаж байна.

ХААН Банкны шинэ оюутны тэтгэлэг хүртэж байсан, анх элсэн орсон сургуульдаа жил завсардалгүй суралцаж буй оюутнуудыг ХААН Банк үргэлжлүүлэн дэмжиж, тэтгэлэгт дахин шалгаруулж, их дээд сургуулийн сургалтын төлбөрийн тодорхой хувийг тэтгэлгээр олгох юм.

**Тэтгэлгийн хэмжээ:** 1,500,000 төгрөг

**Тэтгэлэг хүсэгчид тавих үндсэн шалгуур:**

- ХААН Банкны шинэ оюутны тэтгэлгийг хүртэж байсан байх
- Тэтгэлэг хүсэгч нь элсэн орсон их, дээд сургуульдаа тэтгэлэг зарласан хугацаанд суралцаж байх;
- Оюутны голч дүн 2.5 ба түүнээс дээш байх
- Өрхийн амьжиргааны түвшнийг тодорхойлсон байх
- Нийгмийн идэвх, эрдэм шинжилгээний хурал, сайн дурын клуб, эсвэл олон нийтийн арга хэмжээ, уралдаан тэмцээнд оролцсон байх

**Тэтгэлэг хүсэгчийн бүрдүүлэх материал:**

- Анкет, цээж зураг (3x4 хэмжээтэй) /Онлайн холбоосоор бөглөх/;
- Оюутны үнэмлэхний хуулбар;
- Сурлагийн дүнгийн тодорхойлолт
  - 2022-2023 оны хичээлийн жил (хэрэв байвал)
  - 2023-2024 оны хичээлийн жил (хагас жил байж болно)-ийн сурлагын дүнгийн дэлгэрэнгүй хуулбарын эх хувь
- /Семестр, семестрээр нь дүнг жагсааж тамгаар баталгаажуулсан байх/
- Багшийн тодорхойлолт;
- Тэтгэлэг хүсэгчийн сургуулийн сургалтын албаны тодорхойлолт;
- “ХААН Банкны нэрэмжит шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөр” хүртэж байсан Эрхийн бичгийн хуулбар
- “Би Монголын ирээдүй” сэдвийн хүрээнд 500-гаас дээш үгтэй эсээ бичих;

**Жич:** Хугацаа хоцроож ирүүлсэн материалыг хүлээн авахгүй бөгөөд хүлээн авсан материалыг буцаан олгохгүйг анхаарна уу.

**Сонгон шалгаруулалт:**

- ХААН Банкны ажилтнуудын төлөөллөөс бүрдсэн Сонгон шалгаруулах комисс сонгон шалгаруулалтыг явуулна.
- Шалгарсан оюутнуудад эрхийн бичиг гардуулах бөгөөд оюутны үнэмлэх, биеийн байцаалтын хуулбарыг үндэслэн ХААН Банк Сан эрхийн бичгийг баталгаажуулна.
- Тухайн их дээд сургуулийн төлбөр ямар байхаас үл хамааран эрхийн бичигт заасан мөнгөн дүнг оюутнуудад тэтгэлэг болгон олгоно.

**Материал хүлээн авах хугацаа:**

Өргөдлийн материалыг **2024 оны 5-р сарын 6-ны өдрөөс 5-р сарын 20-ны өдрийн 18:00 цаг хүртэл **онлайнаар**** хүлээн авна.



QR уншуулах эсвэл **ЭНД** дарж анкетыг бөглөх боломжтой.

**Шалгаруулалтын дүнг зарлах:**

Шилдэг 40 оюутны нэрсийг **2024 оны 5-р сарын 31-нд** ХААН Банкны вэбсайт, албан ёсны социал сувгуудаар мэдээлнэ.

**Нэмэлт мэдээлэл авах:** ХААН Банкны **1800-1917** лавлах утас болон [www.khanbank.com](http://www.khanbank.com) вэбсайтаар хандана уу.